

ХОВД ИХ СУРГУУЛЬ
ГАДААД ХЭЛ, СОЁЛЫН СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДЛАЛ, АРГАЗҮЙН ТЭНХИМ

ДАМДИНСҮРЭНГИЙН НЯМДАВАА

АМЬДРАЛЫН БУРУУ ХЭВШЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ
ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ДАДЛЫН
СУДАЛГАА
(Зүрх судасны тогтолцооны өвчин)

Мэргэжлийн индекс: E01110101

Боловсрол судлалын ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

ХОВД ХОТ
2017 ОН

“Амьдралын буруу хэвшилээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын судалгаа” сэдэвт боловсрол судлалын магистрын зэрэг горилсон энэхүү бүтээлийг Ховд их сургуулийн Гадаад хэл, соёлын сургуулийн Боловсрол судлал, аргазүйн тэнхимд гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний удирдагч:

Доктор (Ph.D) Д.Өнөрнасан

Албан ёсны шүүмжлэгч:

Доктор (Ph.D), Дэд проф. В.Сайнбаяр

Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хурал 2017 оны 05 сарын 19-ний өдөр ХИС-ийн хичээлийн II байранд тоотод болно.

Боловсрол судлал ухааны магисрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга:

доктор (Ph.D) О.Мөнхжаргал

ХОВД ИХ СУРГУУЛЬ
ГАДААД ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДЛАЛ, АРГА ЗҮЙН ТЭНХИМ

Дамдинсүрэнгийн Нямдаваа

АМЬДРАЛЫН БУРУУ ХЭВШЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ
ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ДАДЛЫН
СУДАЛГАА

Мэргэжлийн индекс: Боловсрол судлал E01110101

Боловсрол судлалын магистрын зэрэг горилсон бүтээл

ХОВД ХОТ
2017 ОН

ГАРЧИГ

Хүснэгтийн жагсаалт.....	ii
Графикийн жагсаалт.....	ii
Товчилсон үгийн тайлбар	iii
УДИРТГАЛ.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН БУРУУ ХЭВШЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ТАРХАЛТ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА	6
1.1 Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчин, түүний тархалт	6
1.2 Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчин ба эрүүл мэндийн боловсрол	21
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ДАДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА.....	28
2.1 Зүрх судасны тогтолцооны өвчнөөс зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг , дадлын асуудал хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал	28
2.2 Зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын судалгаа	34
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	46
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	49
ХАВСРАЛТ.....	51

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Насанд хүрсэн хүний зөв хооллолтын “ГЭР” зөвлөмж.....	10
Хүснэгт 2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн хөтөлбөрүүд	28
Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагсадын амьдралын буруу хэвилийг үүсгэдэг хүчин зүйлийн илэрц.....	39
Хүснэгт 4. Амьдралын буруу хэвилийг үүсгэж байгаа хүчин зүйлийн талаарх мэдлэгийн түвшин.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5. Заавал хэвшүүлэх дадлын мэдлэгийн сургалтын өмнөх ба дараах төлөв	43

Графикийн жагсаалт

График 1. Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж буй анхдагч эрсдэлт хүчин зүйлс	7
График 2. Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж буй завсрын хүчин зүйлс	8
График 3. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан улсын хэмжээнд /10 000 хүн амд/	17
График 4. Зүрх судасны тогтолцооны өвчлөл /10 000 хүн амд/	18
График 5. Ховд аймгийн хүн амын зүрх судасны тогтолцооны өвчлөлийн байдал.....	19
График 6. Ховд аймгийн хэмжээнд зүрх судасны тогтолцооны өвчлөлийн нас баралт сүүлийн /5 жилээр/	20
График 7. Эрүүл мэндийн гурвалжин.....	21
График 8. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйл	22
График 9. Асуулга судалгаанд хамрагдагсadyг насны байдал	34
График 10. Асуулга судалгаанд хамрагдагсadyн хүйсийн харьцаа	34
График 11. Асуулга судалгаанд хамрагдагсadyн боловсролын түвшин	35
График 12. Судалгаанд хамрагдагсadyн өрхийн сарын орлогын мэдээлэл	35
График 13. Судалгаанд хамрагдагсadyн зүрх судасны тогтолцооны өвчлөлийн байдал	36
График 14. Судалгаанд хамрагдагсадаас зүрх судасны тогтолцооны өвчнөөр өвчилсөн байдал	36
График 15. Зүрх судасны тогтолцооны өвчний талаарх мэдлэгийн байдал.....	37
График 16. Зүрх судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн боловсролын түвшин.....	37

График 17. Зүрх судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн эрүүл мэндийн мэдээлэл авдаг хэлбэр.....	38
График 18 Амьдралын буруу хэвшлийг үүсгэж байгаа хүчин зүйлийн талаарх мэдлэгийн түвшин	40
График 19. Зүрх судасны өвчний талаарх мэдлэгийн түвшин.....	40
График 20. Зүрх судасны өвчинд хэрэглэдэг эмийн мэдлэгийн түвшин	41
График 21.Амьдралын буруу хэвшлийг үүсгэж байгаа хүчин зүйлийн талаарх мэдлэгийн түвшин	41
График 22. Эрүүл мэндийн дадлын үзүүлэлт	42

Товчилсон үгийн тайлбар

ЗСТӨ	Зүрх судасны тогтолцооны өвчин
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ХБӨ	Халдварт бус өвчин
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АББ	Албан бус боловсрол
МХХТ	Мэдээлэл харилцаа холбооны технологи
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ММСС	Монголын Мянганы Сорилтын Сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БЖИ	Биеийн жингийн индекс
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв

УДИРТГАЛ

Дэлхий нийт өнөөдөр тогтвортой хөгжлийн асуудлыг чухалчлан үзэж, хэлэлцэж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган АНУ-ын Нью-Йорк хотноо салбар хуралдаанаараа "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийг баталсан¹. Тогтвортой байдал гэдгийг сайн сайхан ирээдүйн төлөө нийгэм, хувь хүмүүсийн хариуцлагатай үйл ажиллагаа гэж ойлгож байна. "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрт тусгасан 17 зорилтын 3-р зорилт нь "Эрүүл мэндийг дэмжих", 4-р зорилт нь "Чанартай боловсролыг дэмжих" гэж тодорхойлсон.

Монгол улс мөн энэ чиг хандлагатай уялдуулан өөрийн улсын үзэл баримтлалыг дэвшүүлэн гаргасан. "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ийн 6-р зорилтод "Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ²" гэж заасан. Энэ хүрээнд нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэхэд чиглэхээр авч үзсэн.

Нөгөө талаас дэлхийн хэмжээний баримт бичгүүдэд боловсрол тогтвортой хөгжилд хөтлөх хүчирхэг арга зам, тогтвортой хөгжлийн боловсрол нь бидний ирээдүйдээ оруулж буй хөрөнгө оруулалт болохыг онцолж байна. Үүнтэй уялдаад боловсрол ба суралцахуйг шинэ чиглэлд хандуулах, тогтвортой хөгжлийг дэмжих бүхий л хөтөлбөр, үйл ажиллагаанд боловсрол ба суралцахуйг нягт холбох шаардлага тулгарч, улс орнууд өөрийн орны онцлог, уламжлал, соёлыг харгалзан энэ чиглэлээр чармайлт гарган ажиллаж байна.

Хүний хөгжлийн гол үзүүлэлтийн нэг бол эрүүл мэнд юм. Дэлхий дахинд хүн амын өвчлөлийн байдал өөрчлөгдөж соёл иргэншил, амьдралын буруу хэв маяг буюу зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээтэй холбоотой халдварт бус өвчнөөр өвчлөгсдийн тоо асар хурдацтай нэмэгдэж

¹ United nation. (2015). *2030 Agenda for Sustainable Development*.

² Монгол Улсын Их Хурал. *Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*. Улаанбаатар, 2016 оны 19-р тогтоол.

нийгэм, эдийн засгийн хөгжил болоод сая сая хүний амьдрал, эрүүл мэндэд давхар дарамт учруулж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр 1995 оноос хойш халдварт бус өвчний дунд зүрх судасны тогтолцооны өвчин нэгдүгээр байр эзэлж, хүн амын нас баралтын үндсэн шалтгаан болж байна³.

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын 2015 оны статистик мэдээллээр нийт хүн амын хувьд авч үзэхэд 5591 хүн, 10000 хүн амд ногдох байдлаар 18.473 нь зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барж байна⁴.

Амьдралын буруу хэвшилээс үүдэлтэй халдварт бус өвчнөөс шалтгаалсан нас баралт манай улсын хүн амын нийт нас баралтын дотор 72 хувийг эзэлж, энэ нь 70-аас доош насныхны эрэгтэйчүүдийн дунд 69.2 %, эмэгтэйчүүдийн дунд 54.7 % байна. Дээрх үзэл баримтлал, асуудлын хүрээнд иргэдийн эрүүл мэндийн боловсролын байдлыг судлах хэрэгцээ шаардлага тулгарч байна⁵.

Ховд аймгийн хүн амын хэмжээнд 2015 оны байдлаар зүрх судасны тогтолцооны өвчний нас баралт, өвчлөл нь буурахгүй байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр 1995 оноос хойш зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нийт хүн амын 3 хүний 1 нь нас барж байна. Үүнээс үзэхэд зүрх судасны тогтолцооны өвчний нас баралт баруун бүсэд өндөр байгаа нь энэ сэдвийг судлах үндэслэл боллоо.

Сэдвийн судлагдсан байдал

Халдварт бус зарим өвчний талаарх мэдлэг, өвчлөл, нас баралт, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрүүл мэндийн боловсрол олголтын талаар докторын болон магистрын судалгааны ажлын хүрээнд тодорхой төвшинд судлагдсан байна. Тухайлбал:

³ World Health Organization. (2005). World Health report.

⁴ Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн яам. (2015). *Эрүүл мэндийн үзүүлэлт*. Х-142

⁵ Монгол Улсын Засгийн Газар. (2014). *Амьдралын буруу хэвшилээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр*.

- Б.Анхбаяр, Ө.Цолмон, Д.Отгонбаяр нарын “Ховд аймгийн ахмад настны эрүүл мэндийн байдал, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс”
- Г.Анхзаяагийн “Зүрх судасны тогтолцооны өвчлөл, нас баралтын төлөв ба нийгэм эдийн засгийн зарим хүчин зүйл”
- Н.Алтайбаатарын “Булган аймгийн төрийн албан хаагчдын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, түүний талаарх мэдлэг, хандлага, дадал”
- Ч.Пүрэвзэгийн “Халдварт бус өвчний талаарх оюутнуудын мэдлэгийн түвшинг тодорхойлох”,
- Т.Энхзулын “Монголын мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн хүрээн дэх халдварт бус зарим өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт” бүтээлүүдэд халдварт бус өвчнийг үүсгэх хүчин зүйл, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, мэдлэг дадал, түүнд хамаарах асуудлын талаар судлан үзсэн байна.

Судалгааны зорилго

Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчний тархалт, өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлыг судлах

Судалгааны зорилт

Зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчний тархалт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа хийх
- Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлын өнөөгийн байдлыг хөтөлбөрүүд болон иргэдийн мэдлэг, дадлын хүрээнд судлах

Судлах зүйл

Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадал

Судалгааны хүрээ

Ховд аймгийн Жаргалант сумын иргэд, эмч, эмнэлгийн мэргэжилтэн

Судалгааны арга зүй

“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын судалгаа” сэдвийн хүрээнд хийсэн судалгаандаа дараах аргуудыг ашиглалаа. Үүнд:

- *Асуулгын арга.* Судалгааны ажлын хүрээнд түүвэр судалгааг авахад ашигласан.
- *Баримт бичиг судлах арга.* Эрүүл мэндийн боловсролын талаарх дэлхий нийт болон Монгол улсын үзэл баримтлал, тунхаг бичиг, гол гол бүтээл, судалгааны өгүүлэл, тайлан, хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөрүүдийг судалсан.
- *Харьцуулалтын арга.* Судалгаанд хамрагдагсадын эрүүл мэндийн боловсролын байдлыг тооцох, үнэлэхэд ашигласан.
- *Ажиглалтын арга.* Судалгааны ажлын чиглэл, сэдвийг сонгохын тулд ажиглалт хийх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөл эрүүл мэндийн боловсролтой хэрхэн холбогдож буй үйл явцыг тандахад хэрэглэлээ.

Судалгааны шинэлэг тал

Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын судалгааг хийснээр

- Эрүүл мэндийн боловсролын судалгаанд хувь нэмрээ оруулна.
- Судалгааны үр дүнг ашиглан тодорхой хүрээнд санал зөвлөмж дэвшүүлнэ
- Ховд аймгийн түвшинд анх судалж байгаа нь шинэлэг юм.

Судалгааны ажлын ач холбогдол

Эрүүл мэндийн боловсрол олгох үйл явцыг сайжруулахад санал дэвшүүлэх

Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал

Бид судалгааны ажлаа хэсэгчилсэн байдлаар ХИС-ийн ГХСС-ийн “Залуу судлаач” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэв.

Судалгааны ажлын бүтэц, бичлэг

Уг бүтээлийн бичлэг, эшлэл, ном зүйг олон улсад нийтлэг ашиглагддаг АРА загвар⁶ болон БШУ-ны сайдын 2014 оны 09 дүгээр сарын А/370 дугаар тушаал⁷-ын хавсралтад заасны дагуу бичсэн болно.

Судалгааны ажлын бичлэг нь нийт 50 хуудастай ба 24 график, 5 хүснэгт, товчилсон үгийн тайлбар, удиртгал хэсэг, үндсэн 2 бүлэг, 4 зүйл, дүгнэлт, ашигласан материалын жагсаалт, хавсралтаас бүрдэнэ.

"Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчний тархалт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа" сэдэв бүхий нэгдүгээр бүлгээр эрүүл мэндийн боловсролын талаарх үзэл баримтлал, бидний судалгааны гол сурвалж болох амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцооны өвчин, түүний тархалт дэлхий нийт болон монгол улс, ховд аймгийн хэмжээнд ямар түвшинд байгааг баримтат мэдээлэлд тулгуурлан судалсан үр дүнгээ, "зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын өнөөгийн байдалд хийсэн судалгаа" гэсэн хоёрдугаар бүлэгт зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр зорьж буй хөтөлбөрүүд, тэдгээрийн хүрээнд ямар мэдлэг, дадал хэвшүүлэх талаарх судалгаа, ховд жаргалант сумын жишээн дээр зүрх судасны тогтолцооны өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын өнөөгийн байдалд хийсэн судалгааны үр дүнгээ орууллаа.

⁶ Америкийн сэтгэл судлалын агентлагаас гаргасан шинжлэх ухааны шинжлэх ухааны судалгааны бүтээлийн хэвлэлийн загвар

⁷ БШУ-ны Сайдын 187 дугаар тушаалын хавсралт, (2014) , *Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай*